



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ  
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

---

**САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН**

Аудитын код: ГСА-2018/47/СТА-ТШЗ

**БОЛОВСРОЛ,  
СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗАР  
2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

(2017 оны 12 дугаар сарын 31-нээр  
дуусвар болсон)

2018.02.24



# АЙМГИЙН БОЛОВСРОЛ, СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗАР

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл  
дараах хаягаар харилцана уу:

ТАБ-ын Дарга, Тэргүүлэх аудитор  
Б.Сарантуяа  
Утас: 70543156  
Цахим хаяг: [sarantuyab@audit.gov.mn](mailto:sarantuyab@audit.gov.mn)

Аудитын менежер Г.Наранбаяр  
Утас: 70543179  
Цахим хаяг: [nananbayarg@audit.gov.mn](mailto:nananbayarg@audit.gov.mn)

Аудитор М.Ундармаа  
Утас: 70543151  
Цахим хаяг: [undarmaam@audit.gov.mn](mailto:undarmaam@audit.gov.mn)

Хаяг: ГСА, Сүмбэр сум 3-р баг, Нутгийн  
удирдлагын ордон 2 давхар

## Аудитын тайлан

### Агуулга

1. Аудитын гэрчилгээ
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан
3. Төсвийн гүйцэтгэлийн тайлан
4. Менежментийн захидал



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг  
Утас/Факс:976-7054 3179  
И-мэйл: goviumber@audit.gov.mn

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН  
БОЛОВСРОЛ, СОЁЛ, УРЛАГИЙН  
ГАЗРЫН ТӨСВИЙН ЗАХИРАГЧ  
Д.ПҮРЭВЦЭЦЭГ ТАНАА**

2018.02.25 № ТТА-2018/44/СТА-ТМЗ

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Говьсүмбэр аймгийн “Боловсрол, соёл, урлагийн газар”-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Говьсүмбэр аймгийн “Боловсрол, соёл, урлагийн газар”-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Говьсүмбэр аймгийн “Боловсрол, соёл, урлагийн газар”-ын 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус газарт мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Г80065

## Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.САРАНТУЯА

